



2022 ОНЫ ОЛОН ҮНДЭСТНИЙ ЦАГААЧЛАЛЫН ВИЗИЙН ХӨТӨЛБӨРИЙН ЗААВАРЧИЛГАА (DV-2022)

Хөтөлбөрийн агуулга

Төрийн департамент жил бүр хуулиар тогтоогдсон эрхийн дагуу Олон үндэстний цагаачлалын визийн хөтөлбөрийг зохион байгуулдаг. Цагаачлал ба харьяаллын тухай хуулийн (ЦХТХ) 203 (с) хэсэгт заасан нөхцлийн дагуу “олон үндэстний цагаачид” гэгдэх цагаачлалын визийн ангилал нь Америкийн Нэгдсэн Улсад цагаачилсан иргэдийн тоогоороо бага улсын иргэдэд зориулагдсан юм. 2022 оны санхүүгийн жилд 55,000 олон үндэстний виз (DV) олгохоор боллоо. Энэхүү хөтөлбөрт бүртгүүлэхэд ямар нэгэн төлбөр төлөхгүй.

Хөтөлбөрт хожсон хүмүүс энэ төрлийн виз авах энгийн боловч нарийн шалгуурыг хангасан байх шаардлагатай. Энэ хөтөлбөр компьютераар, санамсаргүй сугалах байдлаар хожигчийг шалгаруулдаг. Визийг газарзүйн зургаан бүсэд хуваарилдаг бөгөөд бүс бүрийн доторх аливаа улс тухайн жилийн олон үндэстний визийн долоон хувиас илүүг авч болдоггүй.

Дараах улс орнуудад төрсөн иргэд DV-2022 хөтөлбөрт өргөдөл гаргах эрхгүй. Учир нь эдгээр улс орнуудаас өмнөх таван жилийн хугацаанд АНУ руу 50,000-аас олон иргэд цагаачилсан байна. Үүнд:

БАНГЛАДЕШ, БРАЗИЛ, КАНАД, ХЯТАД (Хонконгийн Тусгай захиргааны бүс оролцуулан), КОЛУМБИ, БҮГД НАЙРАМДАХ ДОМИНИКАН УЛС, ЭЛЬ САЛЬВАДОР, ГУАТЭМАЛА, ГАИТИ, ГОНДУРАС, ЯМАЙКА, МЕКСИК, НИГЕР, ПАКИСТАН, ФИЛИППИН, ӨМНӨД СОЛОНГОС, ИХ БРИТАНИ (Умард Ирландыг оруулахгүй) ба түүний хараат нутаг дэвсгэрүүд мөн ВЬЕТНАМ.

Макаогийн Тусгай захиргааны бүс болон Тайваньд төрсөн иргэд оролцох эрхтэй.

Хөтөлбөрт оролцох эрх

Тавигдах шалгуур #1: АНУ-д цагаачилсан иргэдийн тоогоороо бага улсын уугуул иргэд хөтөлбөрт оролцох эрхтэй.

Хэрэв та АНУ-д цагаачилсан иргэдийн тоогоороо бага улсын уугуул иргэн биш бол хөтөлбөрт оролцох өөр хоёр арга бий.

- Таны эхнэр/нөхөр АНУ-д цагаачилсан иргэдийн тоогоороо бага улсын уугуул иргэн мөн үү? Хэрэв тийм бол, та эхнэр/нөхрийнхөө төрсөн улсаар төлөөлүүлэн хамтдаа хөтөлбөрт оролцож шалгуур хангасан тохиолдолд хоёулаа виз авч АНУ руу цагаачлах боломжтой болно.
- Та АНУ-д цагаачилсан иргэдийн тоогоороо бага биш улсын уугуул бөгөөд эцэг эх тань тэнд төрөөгүй, таныг төрөх үед тэндхийн оршин суугч байгаагүй юу? Хэрэв тийм бол та оролцох эрхтэй улс оронд төрсөн эцэг/эхийнхээ аль нэгний төрсөн улс орныг өөрийн төрсөн улс болгон DV-2022 хөтөлбөрт оролцож болно. Энэ талаарх нэмэлт мэдээллийг Түгээмэл асуултаас үзнэ үү.

Тавигдах шалгуур #2: Виз мэдүүлэгч бүр DV хөтөлбөрийн боловсрол ба ажлын туршлагын шалгуурыг хангасан байх ёстой. Үүний тулд:

- Хамгийн багадаа ахлах сургуулийн боловсрол буюу түүнтэй адилтгах боловсролтой байх, тухайлбал бага болон дунд боловсролын 12 жилийн сургалтыг амжилттай дүүргэсэн байх;

ЭСВЭЛ

- Өнгөрсөн таван жилийн хугацаанд дор хаяж хоёр жилийн сургалт буюу туршлага шаардах мэргэжлээр хоёр жил ажилласан туршлагатай байх ёстой. АНУ-ын Хөдөлмөрийн яамны [O*Net Online](#) мэдээллийн сангаас шаардлага хангасан ажлын жагсаалтыг харж болно.

Шалгуур хангах ажлын талаарх нэмэлт мэдээллийг Түгээмэл асуултаас үзнэ үү.

Та дээрх 2 шалгуурыг хангаж чадахгүй байгаа тохиолдолд DV хөтөлбөрт бүртгүүлэх хэрэггүй.

DV хөтөлбөрийн бүртгэлийн хугацаа

Оролцогчид DV-2022 Олон үндэстний визийн хөтөлбөрт 2020 оны 10 сарын 7-ны Лхагва гаригийн АНУ-ын Зүүн эргийн өдрийн цагийн бүсийн (Eastern Daylight Time) (GMT-4) үдийн 12.00 цагаас 2020 оны 11 сарын 10-ны Мягмар гаригийн АНУ-ын Зүүн эргийн стандарт цагийн бүсийн (EST) (GMT-5) үдийн 12.00 цаг хүртэл электрон хэлбэрээр dvprogram.state.gov цахим хуудсаар бүртгүүлэх ёстой. Бүртгэлийн хугацааны сүүлийн долоо хоног хүртэл хүлээх хэрэггүй. Учир нь хэт их ачааллаас болж цахим хуудас гацаж болзошгүй юм. Хуулийн дагуу тухайн жилийн хөтөлбөрт нэг хүний нэр дээр зөвхөн нэг бүртгэл оруулах боломжтой. Хөтөлбөрт давхар бүртгүүлсэн хүмүүсийг системээр хялбархан илрүүлдэг. **Нэгээс олон удаа бүртгүүлсэн оролцогч DV хөтөлбөрт оролцох боломжгүй болно.**

DV-2022 Электрон бүртгэлийн талаарх мэдээлэл

Та dvprogram.state.gov хаягаар орж Олон үндэстний визийн DS-5501 электрон бүртгэлийн маягтыг (E-DV бүртгэл) бөглөж оруулах ёстой. Бүрэн бөглөөгүй маягтыг хүлээж авахгүй. DV хөтөлбөрт оролцоход ямар нэгэн төлбөр байдаггүй. Маягт бөглөж оруулахдаа шинэчлэгдсэн интернэт хөтөч ашиглана уу. Учир нь Internet Explorer 8 шиг хуучин интернэт хөтөч ашиглавал цахим DV бүртгэлийн системд асуудал үүсгэж болзошгүй.

“Визийн зөвлөгөө”, “Виз зуучлагч” зэрэг таны өмнөөс хөтөлбөрийн бүртгэлийн маягт бөглөж өгөхөөр санал тавьсан аливаа зуучлагчаар биш аль болох өөрөө бүртгүүлэхийг бид зөвлөж байна. Хэрэв та хэн нэгнээс туслалцаа авч бүртгүүлэхээр бол бүртгүүлж байх явцад дэргэд нь байж бүртгэлийг баталгаажуулсан хуудас болон бүртгэлийн дугаараа өөртөө хадгалж авч үлдэх хэрэгтэй. Энэ нь маш чухал юм. Учир нь дараа нь энэ мэдээлэлгүйгээр цахим хуудас руу орж хөтөлбөрт шалгарсан эсэхээ мэдэх боломжгүй. Хэн нэгэнд өөрийн бүртгэлийн мэдээллийг өгөхөөс болгоомжлохыг сануулж байна. Мөн та E-DV бүртгэлийн маяганд бүртгүүлсэн имэйлээ шалгахад хэрэгтэй мэдээллийг өөртөө хадгалах хэрэгтэй. Олон үндэстний визийн хөтөлбөрийн залилангийн талаарх нэмэлт мэдээллийг Түгээмэл асуултаас үзнэ үү. Та манай олон үндэстний визийн хөтөлбөрийн талаархи танилцуулга болон хэрхэн бүртгүүлэх дэлгэрэнгүй зааварчилгааны тухай дүрс бичлэгийг [эндээс](#) үзэх боломжтой.

Бүртгэл амжилттай болсон тохиолдолд таны нэр болон бүртгэлийн дугаартай баталгаажуулсан хуудас дэлгэц дээр гарч ирнэ. Та энэхүү хуудсыг хэвлэж гаргаад бүртгэлийн дугаараа хадгалах хэрэгтэй. 2021 оны 5 сарын 8-наас эхлэн dvprogram.state.gov вэб хуудасны Entrant Status Check программ руу орж өөрийн бүртгэлийн дугаар хувийн мэдээллээ оруулж хөтөлбөрийн явцыг шалгах боломжтой. Та DV-2022 хөтөлбөрт шалгарсан эсэхээ мэдэх, өргөдлөө цаашид хэрхэн үргэлжлүүлэх зааварчилгаа харахдаа ENTRANT STATUS CHECK программыг ашиглах ёстой. АНУ-ын Засгийн газраас танд шууд мэдээлэл өгөхгүй. ENTRANT STATUS CHECK программ бол таны DV-2022 хөтөлбөрт шалгарснаа мэдэх цорын ганц арга юм. Хэрэв та хөтөлбөрт сонгогдож визийн өргөдөл болон шаардлагатай бичиг баримтыг өгсөн бол ENTRANT STATUS CHECK программ ашиглан цагаачлалын визийн ярилцлагын хувиарийг шалгах ёстой. Хөтөлбөрийн процессын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Түгээмэл асуултаас үзнэ үү.

Хөтөлбөрийн бүртгэлийн маяганд та дараах мэдээллийг оруулах ёстой. Мэдээллээ бүрэн зөв оруулаагүй тохиолдолд та DV хөтөлбөрт оролцох боломжгүй болно.

1. БҮТЭН НЭР - Овог, нэр. Гадаад паспорт дээр бичигдсэн байдлаар оруулна. Хэрэв та зөвхөн нэг нэртэй (овог болон нэрийн аль нэг нь л байдаг) бол бүртгэлд оруулахдаа овог бичих хэсэгт нэрээ бөглөж оруулах шаардлагатай.
2. ХҮЙС – Эр/Эм
3. ТӨРСӨН ОГНОО - Өдөр, сар, он
4. ТӨРСӨН ХОТ

5. ТӨРСӨН УЛС – Улс орны нэр нь таны төрсөн улсын одоогийн нэр байх ёстой.
6. DV ХӨТӨЛБӨРТ ОРОЛЦОХ ЭРХТЭЙ УЛС – Таны төрсөн орон тус хөтөлбөрт оролцох эрхтэй орнуудын нэг байх ёстой. Оролцох эрхтэй орон гэдэг нь таны одоо амьдарч байгаа газар эсвэл таны иргэншил (төрсөн улсын иргэншлээс өөр иргэншилтэй тохиолдолд). Хэрэв та DV хөтөлбөрт оролцох эрхгүй улс оронд төрсөн бол, хөтөлбөрт оролцож болох өөр хувилбар байгаа эсэхийг Түгээмэл асуултаас үзнэ үү.
7. Таны хүчинтэй, хугацаа нь дуусаагүй гадаад паспортын дугаар, олгосон улс, дуусах хугацаа. Энэхүү шаардлага нь үндсэн оролцогчдод л хамааралтай бөгөөд гэр бүлийн гишүүдэд хамааралгүй болно. Хүчинтэй паспортын мэдээлэл оруулаагүй тохиолдолд та DV хөтөлбөрт оролцох боломжгүй болно.
8. БҮРТГЭЛИЙН ЗУРАГ – Та өөрийнхөө зургаас гадна эхнэр/нөхөр мөн бүртгүүлсэн бүх хүүхдийнхээ (сүүлийн 6 сард авахуулсан) зургуудыг оруулах ёстойг анхаарна уу. Дижитал зургийн үзүүлэлтийн талаарх мэдээллийг үзнэ үү. Хэрэв эхнэр/нөхөр эсвэл хүүхэд тань АНУ-ын иргэн эсвэл Хууль ёсны байнгын оршин суугч бол зураг оруулах шаардлагагүй бөгөөд зургийг нь оруулсан тохиолдолд ямар нэгэн асуудал үүсэхгүй.

DV хөтөлбөрийн зургийн шаардлага АНУ-ын визийн зурагтай ижил шаардлагатай байна. Хэрэв таны болон гэр бүлийн гишүүдийн оруулсан зураг шаардлагад нийцээгүй эсвэл засвартай зураг оруулсан тохиолдолд та DV хөтөлбөрт оролцох боломжгүй болно. Өнгөрсөн жилийн хөтөлбөрт оруулсан зургийг дахин ашиглавал мөн хүчингүйд тооцно. Дижитал зураг хэрхэн оруулах шаардлагыг 7-р хуудаснаас үзнэ үү.

9. ШУУДАНГИЙН ХАЯГ – Хүлээн авагчийн нэр
Хаягийн мөр 1
Хаягийн мөр 2
Хот/Аймаг
Дүүрэг/Сүм
Шуудангийн код/Зип код
Улс

9. ОДОО АМЬДАРЧ БУЙ УЛС.

10. УТАСНЫ ДУГААР (заавал бөглөх шаардлагагүй).
11. ИМЭЙЛ ХАЯГ - Дараа жилийн 5 сараас эхлэн сонгогдсон оролцогчдод мэдэгдэл өгдөг тул та өөрийн байнга хэрэглэдэг бөгөөд дараа жил үргэлжлүүлэн ашиглах боломжтой имэйл хаягаа оруулах хэрэгтэй. Та сонгогдсон тохиолдолд Entrant Status Check программаар орж шалгарснаа мэдээд мэдэгдэлд нь хариу өгсний дараа Төрийн департаментас Entrant Status Check рүү орж визэнд орох товоо харах зааварчилгааг таны энэ хаяг руу имэйлээр ирүүлнэ. Төрийн

департаменттаас таныг хөтөлбөрт шалгарсан гэдгийг ХЭЗЭЭ ч имэйлээр эхэлж мэдэгдэхгүй. Хөтөлбөрийн процессын талаарх нэмэлт мэдээллийг Түгээмэл асуултаас үзнэ үү.

12. ӨНӨӨДРИЙН БАЙДЛААР ТАНЫ ЭЗЭМШСЭН БОЛОВСРОЛЫН ДЭЭД ТҮВШИН – Таны эзэмшсэн боловсролын хамгийн дээд түвшинг илтгэж байгаа нэг хариултыг тэмдэглэх ёстой: (1) Бага сургууль төгссөн, (2) Ахлах сургуулийг гэрчилгээгүй төгссөн, (3) Ахлах сургуулийг гэрчилгээтэй төгссөн, (4) Мэргэжлийн сургууль төгссөн, (5) Их сургуулийн зарим курсыг дүүргэсэн, (6) Их сургуулийг зэрэгтэй төгссөн, (7) Их сургуулийн дараах түвшний сургалт дүүргэсэн, (8) Магистрын зэрэгтэй, (9) Докторын түвшний зарим курс дүүргэсэн, эсвэл (10) Докторын зэрэгтэй. Энэ талаарх нэмэлт мэдээллийг Түгээмэл асуулт дотроос үзнэ үү.
13. ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ - (1) Гэрлээгүй, (2) гэрлэсэн бөгөөд миний эхнэр/нөхөр АНУ-ын иргэн эсвэл хууль ёсны байнгын оршин суугч биш, (3) гэрлэсэн бөгөөд миний эхнэр/нөхөр АНУ-ын иргэн эсвэл хууль ёсны байнгын оршин суугч, (4) гэрлэлт цуцлуулсан, (5) бэлэвсэн, эсвэл (6) хууль ёсны дагуу тусдаа амьдардаг. Та эхнэр/нөхрийнхөө овог нэр, төрсөн он сар өдөр, хүйс, төрсөн хот, улсыг техникийн шаардлага хангасан цээж зургийн хамт оруулах хэрэгтэй.

Хууль ёсны эхнэр/нөхрөө оруулаагүй эсвэл эхнэр/нөхөр болоогүй хүнээ оруулсан тохиолдолд хөтөлбөрийн үндсэн хожигчийн хувьд та DV хөтөлбөрт оролцох боломжгүй болж таны эхнэр/нөхөр болон хүүхдүүд DV хөтөлбөрт гэр бүлийн гишүүнээр оролцох эрхгүй болно. Та эхнэр/нөхрөөсөө шүүхийн шийдвэрийн дагуу тусдаа амьдардагаас бусад тохиолдолд эхнэр/нөхрийн нэрийг заавал оруулах ёстойг анхаарна уу. Хуулийн дагуу тусдаа амьдардаг тохиолдол нь гэрлэсэн хэвээрээ хэдий ч шүүхийн шийдвэрийн дагуу тусдаа амьдрахыг хэлнэ. Хэрэв та эхнэр/нөхрөөсөө хуулийн дагуу тусдаа амьдардаг бол таны эхнэр/нөхөр таныг дагаж DV хөтөлбөрт хамрагдан цагаачлах боломжгүй. Та хуулийн дагуу тусдаа амьдардаг эхнэр/нөхрийнхөө нэрийг бүртгэлийн хуудсан дээрээ оруулсан тохиолдолд ямар нэгэн асуудал үүсэхгүй. Харин та DV хөтөлбөр эхлэхээс өмнө гэрлэлтээ цуцлахаар төлөвлөсөн хэдий ч тусдаа амьдардаг гэсэн шүүхийн шийдвэр байхгүй бол эхнэр/нөхрөө заавал оруулах ёстой. Хуулийн дагуу гэрлэсэн эхнэр/нөхрөө бүртгэлийн хуудсан дээрээ оруулаагүй тохиолдолд та DV хөтөлбөрт оролцох боломжгүй болж таны эхнэр/нөхөр болон хүүхдүүд DV хөтөлбөрт гэр бүлийн гишүүнээр оролцох эрхгүй болно.

Хэрэв таны эхнэр/нөхөр АНУ-ын иргэн эсвэл хууль ёсны байнгын оршин суугч бол бүртгэлийн хуудсан дээр оруулж болохгүй. Учир нь АНУ-ын иргэн эсвэл Хууль ёсны байнгын оршин суугчид виз авах шаардлагагүй бөгөөд бүртгэлийн хуудсан дээрээ оруулсан тохиолдолд систем таниас нэмэлт мэдээлэл оруулахыг шаардахгүй болно. Гэр бүлийн гишүүдийн талаарх нэмэлт мэдээллийг Түгээмэл асуултаас үзнэ үү.

14. ХҮҮХДИЙН ТОО - Бүртгэлдээ бүх хүүхдийнхээ овог нэр, төрсөн он сар өдөр, төрсөн газар зэргийг ЗААВАЛ оруулах ёстой. Үүнд таны гэрлээгүй бөгөөд 21 нас хүрээгүй бүх төрсөн хүүхэд, хууль ёсоор

үрчилж авсан болон дагавар хүүхэд орно. Тантай хамт амьдардаггүй, тантай хамт цагаачлахгүй байсан ч гэсэн та бүгдийг нь оруулах ёстой. Хүүхэд тус бүрийн зургийг оруулах бөгөөд зураг бүр техникийн шаардлага хангасан байх ёстой.

Гэрлэсэн хүүхдүүд болон таныг хөтөлбөрт бүртгүүлэх үед **21 болон түүнээс дээш настай** байсан хүүхдүүд таны бүртгэлд орох ёсгүй. Гэхдээ энэхүү насны хязгаарыг давсан хүүхдүүдийг зарим тохиолдолд АНУ-ын хууль тогтоомжоор хамгаалдаг. Та гэр бүл болоогүй хүүхдээ 21 нас хүрэхээс өмнө DV хөтөлбөрт хамрагдсан бөгөөд хүүхэд тань виз авахаасаа өмнө 21 нас хүрсэн бол Хүүхдийн статусыг хамгаалах хуулийн дагуу тэр хүүхдийг 21 нас хүрээгүй гэж үздэг.

АНУ-ын иргэн эсвэл хууль ёсны байнгын оршин суугч хүүхдүүдийг DV хөтөлбөрт бүртгүүлж виз мэдүүлэх шаардлагагүй бөгөөд тэднийг бүртгэлдээ оруулсан эсвэл хассан тохиолдолд ямар нэг асуудал үүсэхгүй.

Та бүртгэлдээ хууль ёсны бүх хүүхдээ оруулаагүй эсвэл өөрийн бус хүүхдийг бүртгэлд оруулсан тохиолдолд та DV хөтөлбөрт оролцох боломжгүй болно. Гэр бүлийн гишүүдийн талаарх нэмэлт мэдээллийг Түгээмэл асуултаас үзнэ үү.

DV-2022 хөтөлбөрийн электрон бүртгэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Түгээмэл асуултаас үзнэ үү.

Оролцогчдыг сонгох

Улс орон, бүс нутагт хуваарилагдсан боломжит визийн оноолтын дагуу шалгуур хангасан бүртгэлүүдээс компьютер санамсаргүй байдлаар хөтөлбөрийг явуулна. DV-2022 хөтөлбөрт оролцогсод бүртгэлийн баталгаажуулсан дугаараа ашиглан E-DV вэб хуудасны Entrant Status Check программ руу орж өөрийгөө сонгогдсон эсэхийг харах шаардлагатай. 2021 оны 5 сарын 8-наас эхлэн 2022 оны 9 сарын 30-ныг дуустал dvprogram.state.gov вэб хуудсаар Entrant Status Check рүү орж шалгаж болно.

Хэрвээ та шалгарсан бол танд визийн төлбөр, АНУ-д цагаачлахтай холбоотой бусад зөвлөмж мэдээлэл бүхий баталгаажуулсан хуудас гарч ирнэ. Entrant Status Check нь таны DV-2022 хөтөлбөрт шалгарсныг мэдээлэх цорын ганц арга юм. Төрийн департамент хөтөлбөрт хожсон тухай мэдэгдлийг шуудан болон имэйлээр явуулахгүй. Түүнчлэн хөтөлбөрт шалгараагүй хүмүүст ч энэ талаар мэдэгдсэн имэйл явуулахгүй. Шалгараагүй хүмүүс хариугаа зөвхөн Entrant Status Check-ээр дамжуулан мэдэж болдог. АНУ-ын Элчин Сайдын Яам, Консулын газрууд сонгогдсон хүмүүсийн нэрсийн жагсаалтыг өгөх боломжгүй. Хөтөлбөрт шалгарсан эсэхээ бусдад найдаж шалгуулахгүйгээр өөрөө E-DV вэб хуудасны Entrant Status Check рүү орж мэдэхийг танд зөвлөж байна.

Хөтөлбөрт хожсоныхоо дараа АНУ-д цагаачлахын тулд та АНУ-ын хуулийн дагуу бүх шалгуурыг хангасан байх ёстой. Үүнд: DS-260 цагаачлалын виз, гадаад иргэний бүртгэлийн цахим анкет бөглөх

мөн Консултай биечлэн ярилцлаганд орж гэмт хэрэг болон аюулгүй байдалтай холбогдох асуултуудад хариулах юм.

Хөтөлбөрт хожсон хүмүүс болон тэдний эрх бүхий гэр бүлийн гишүүдийн визийг 2022 оны 9 сарын 30-ны дотор олгосон байх ёстой. Энэ өдрөөс хойш ямар ч нөхцөлд Төрийн Департамент олон үндэстний виз олгохгүй мөн АНУ-ын Иргэншил ба Цагаачлалын Алба ямар нэгэн өөрчлөлт хүлээн авахгүй бөгөөд гэр бүлийн гишүүд нь хожигчийн хойноос АНУ руу цагаачлах, олон үндэстний виз авах боломжгүй болно.

DV хөтөлбөрийн электрон бүртгэлийн талаарх нэмэлт мэдээллийг Түгээмэл асуултаас үзнэ үү.

Дижитал зураг оруулах заавар

Та дараах үзүүлэлтүүдэд нийцсэн зураг авахуулах эсвэл сүүлийн 6 сарын дотор авахуулсан зураг скайнердаж оруулж болно. DV хөтөлбөрийн зурагны шаардлага АНУ-ын визийн зурагтай ижил шаардлагатай байна. Шаардлага хангасан жишээ зургийг [эндээс](#) харна уу. Сүүлийн зургаан сараас өмнө авахуулсан эсвэл шаардлага хангаагүй зургийг оруулж болохгүй. Өнгөрсөн жилийн (DV-2021) хөтөлбөрт оруулсан, засвартай эсвэл шаардлаганд нийцээгүй зураг оруулвал та DV хөтөлбөрт оролцох боломжгүй болно.

Зурагт тавигдах шаардлага:

- Өнгөт
- Фокус таарсан
- Зурган дээр гарсан таны толгойны хэмжээ 22-с 35 мм (1 инч-с 1 3/8 инч)-н хооронд байх эсвэл толгойны оройгоос эрүүний доод хэсэг хүртэлх нийт зурагны өндөр нь 50%-69%-н хооронд байх. Зургийн хэмжээний шалгуурын талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг [Зургийн загвар хэмжээнээс](#) харна уу.
- Одоогийн гадаад төрхийг тусгахын тулд сүүлийн 6 сарын дотор авахуулсан зураг оруулах
- Цагаан эсвэл гэрэлтэй фоны өмнө зураг авахуулсан байх
- Нүүрийг бүтэн оруулж камер луу эгц чигээрээ харсан байх
- Нүүрний хувирал гаргалгүй нүдээ нээж авахуулсан байх
- Өдөр тутамдаа өмсдөг хувцасаа өмсөж авахуулсан байх
- Өдөр тутам өмсдөг шашны өмсгөлөөс бусад дүрэмт хувцастай авахуулахгүй байх
- Өдөр тутам өмсдөг шашны өмсгөлөөс бусад малгай эсвэл толгой бүтээж үс далдалсан өмсгөл өмсөхгүй байх. Таны нүүр бүтнээрээ ил гарсан байх шаардлагатай бөгөөд толгойны өмсгөлөөс нүүрэн дээр ямар нэгэн сүүдэр тусах ёсгүй.

- Чихэвч, утасгүй төхөөрөмж эсвэл ижил төрлийн ямар нэгэн төхөөрөмжийг зурганд оруулахгүй байх
- Нүдний шил зүүхгүй байх
- Хэрэв та өдөр тутамдаа сонсголын төхөөрөмж зүүдэг бол зурганд оруулж болно.

Жишээ зургийг [эндээс](#) үзэж шаардлага хангасан болон хангахгүй загвар зургийг харна уу. Жолооны үнэмлэх ба бусад албаны бичиг баримтаас хуулбарласан эсвэл сканнердаж оруулсан зураг шаардлага хангахгүй. Мөн түүнчлэн бие бүтнээрээ гарсан зураг, сэтгүүлийн зураг, чанар муу автомат машин эсвэл гар утсаар авсан зураг шаардлагад нийцэхгүй.

Та зургаа бүртгэл хийх явцдаа оруулах ёстой бөгөөд дараах техникийн үзүүлэлтийг хангасан байх шаардлагатай:

- JPEG (.jpg) форматтай байх
- Зургийн файлын хэмжээ 240KB (килобайт)-тай тэнцүү буюу түүнээс доош хэмжээтэй байх
- Дөрвөлжин дүрсний харьцаатай (өндөр өргөн тэнцүү байх)
- 600x600 пикселийн хэмжээтэй байх.

Та өөрт байгаа зургаа сканнердаж оруулах бол тухайн зураг тань техникийн үзүүлэлтийг хангахаас гадна доорхи шалгуурыг мөн хангасан байх ёстой:

- 2 x 2 инч (51 x 51 мм)
- Инч бүрт 300 пиксел (мм бүрт 12 пиксел)-ийн нарийвчлалтай скайнердсан байх.

Төрийн Департаментын [үнэгүй зургийн программыг](#) дараах зааврын дагуу ашиглана. Компьютерт хадгалагдсан зургаа сонгоно:

- Шаардлагатай бол хэмжээг дахин тааруулна
- 600 x 600 пиксел хэмжээтэй дөрвөлжин дүрстэй болгож засна.

Нялх буюу бага насны хүүхдийн зураг авах зөвлөгөө

Нялх буюу бага насны хүүхдийн зургийг авахдаа өөр хүн зурганд оруулалгүй зөвхөн хүүхдийг камер луу харуулж нүд аниулахгүйгээр зургийг нь авна.

Зөвлөгөө 1: Нялх хүүхдээ цагаан эсвэл гэгээлэг өнгийн даавуун дээр нуруугаар нь хэвтүүлнэ. Ингэснээр таны хүүхдийн толгой зураг авахад тэгш байрлалд байж мөн зурагны арын фоны шалгуурыг хангана. Хүүхдийн зургийг авахдаа нүүрэн дээр нь ямар ч сүүдэр тусгахгүй байхыг анхаарна уу.

Зөвлөгөө 2: Хүүхдийн машины суудлыг цагаан эсвэл гэгээлэг өнгийн даавуугаар бүтээж нялх хүүхдээ суудалд нь суулгаж зургийг нь авах. Ингэснээр таны хүүхдийн толгой тэгш байрлалд байх боломжтой.

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТУУД

ХӨТӨЛБӨРТ ОРОЛЦОХ ЭРХ

1. "УУГУУЛ" БОЛОН "НЭРЭЭР НЬ ОРОЛЦОХ" ГЭДЭГ НЬ ЮУ ГЭСЭН ҮГ ВЭ?

Уугуул гэдэг нь одоо оршин суугаа болон харьяалагдах улс орноос нь үл хамааран тодорхой нэг улс оронд төрсөн хүнийг хэлдэг. Цагаачлал ба харьяаллын тухай хуулийн 202(b) хэсэгт заасны дагуу цагаачлалын асуудлын хүрээнд уугуул гэдэгт төрсөн улс орноосоо өөр улс орны нэрээр оролцох эрхтэй хүнийг мөн хамруулж ойлгодог.

АНУ руу цагаачлах нийт хүмүүсийн тоо улс орон эсвэл газар зүйн бүс нутгаас хамааран ялгаатай байх тул хүн бүр аль нэг улс орны нэрээр оролцоно. Нэрээр нь оролцож буй улс орны тооны хязгаар танд хамааралтай. Ихэнх тохиолдолд та төрсөн улсынхаа нэрээр хөтөлбөрт оролцоно. Гэсэн хэдий ч та эхнэр/нөхрийнхөө төрсөн улс, эсвэл эцэг/эхийнхээ төрсөн улсаас өөр улсад төрсөн мөн таныг төрөх үед эцэг эх тань хоюулаа тухайн улс орны оршин суугч биш байсан тохиолдолд эцэг/эхийнхээ төрсөн улс орны нэрээр хөтөлбөрт оролцохоор мэдүүлж болно. Хөтөлбөрт оролцох улс орныг дээрх гурван аргаар л тодорхойлно.

Өөрт хамааралгүй улс орны нэрээр хөтөлбөрт оролцсон оролцогчид DV хөтөлбөрт оролцох боломжгүй болно.

2. БИ ХӨТӨЛБӨРТ ОРОЛЦОХ ЭРХГҮЙ УЛС ОРОНД ТӨРСӨН ХЭДИЙ Ч ОРОЛЦОЖ БОЛОХ НӨХЦӨЛ БИЙ ЮУ?

Энэ тохиолдолд хөтөлбөрт оролцож болох хоёр арга бий. Нэгдүгээрт, хэрэв таны эхнэр/нөхөр хөтөлбөрт оролцох эрхтэй улс оронд төрсөн бол та тухайн улсын нэрээр оролцох эрхтэй болно. Гэхдээ энэ тохиолдолд таны эхнэр/нөхөр мөн шаардлагад тэнцэж, DV-2 виз авсан тохиолдолд л танд DV-1 виз олгох бөгөөд та хоёр DV визээрээ АНУ руу хамт зорчих ёстой. Үүнтэй нэгэн адилаар насанд хүрээгүй хүүхэд эцэг эхийнхээ төрсөн улс орны нэрээр виз авах боломжтой.

Хоёрдугаарт, та эцэг/эхийнхээ төрсөн улс орны нэрээр хөтөлбөрт оролцохоор мэдүүлж болно. Гэхдээ таныг төрөх үед эцэг эх тань хоёулаа хөтөлбөрт оролцох эрхгүй улс орны оршин суугч биш байсан байх ёстой. Ерөнхийдөө хүмүүс аль нэг улсад түр хугацаагаар зорчиж, түр хугацаагаар суралцаж, компани буюу засгийн газрын нэрийн өмнөөс ажил хэргийн буюу мэргэжлийн шалтгаанаар байрлаж байсан тохиолдолд тэнд төрөөгүй буюу хууль ёсоор иргэншил аваагүй бол тухайн улсын оршин суугч гэж тооцогддоггүй.

Хэрэв та төрсөн улс орноосоо өөр улс орны нэрээр хөтөлбөрт оролцож байгаа бол энэ тухай мэдээллээ E-DV электрон бүртгэлийн маягтын 6 дугаар асуултыг бөглөхдөө бичнэ үү.

Таныг хөтөлбөрт оролцох эрхтэй болгож буй улс орон болон нэрээр нь оролцож буй улс орноо буруу бичвэл (өөрөөр хэлбэл нэрээр нь оролцох боломжгүй улс бичвэл) та DV хөтөлбөрт оролцох боломжгүй болно.

3. ЯАГААД ЗАРИМ УЛС ОРНЫ УУГУУЛ ИРГЭД ОЛОН ҮНДЭСТНИЙ ВИЗИЙН ХӨТӨЛБӨРТ ОРОЛЦОХ БОЛОМЖГҮЙ БАЙДАГ ВЭ?

Олон үндэстний виз нь АНУ-д цагаачилсан иргэдийн тоогоороо бага улсын иргэдэд цагаачлах боломж олгох зорилготой. Хуулинд зааснаар АНУ-д цагаачилсан иргэдийн тоогоороо их улс гэдэгт өнгөрсөн таван жилийн хугацаанд Гэр бүлийн болон Хөдөлмөр эрхлэлтийн визээр нийт 50,000 иргэн нь АНУ-д цагаачилсан улс орнуудыг хэлдэг. АНУ-ын Иргэншил, цагаачлалын алба жил бүрийн олон үндэстний визийн хөтөлбөрт оролцох эрхгүй улс орнуудыг тодорхойлохын тулд өнгөрсөн таван жилийн хугацаанд гэр бүлийн болон хөдөлмөр эрхлэлтийн визээр цагаачлагчдын тоог нэмж нийлбэрийг гаргадаг. Жил бүрийн E-DV бүртгэлийн хугацаа эхлэхээс өмнө дээрх нийлбэрийг гаргадаг тул уугуул иргэд нь оролцох эрхгүй улс орнуудын жагсаалт өмнөх жилээсээ өөрчлөгдөх магадлалтай байдаг.

4. DV-2022 ХӨТӨЛБӨРТ ОРОЛЦОХ ЭРХТЭЙ БҮС НУТАГ БОЛОН УЛС ОРОН БҮРИЙН УУГУУЛ ИРГЭДЭД ХУВААРИЛАГДАХ DV ВИЗИЙН ТОО ХЭД ВЭ?

АНУ-ын Иргэншил, цагаачлалын алба (USCIS) нь жил бүр Цагаачлал, харьяаллын тухай хуулийн 203 (с) хэсэгт заасан томъёоллоор бүс нутгуудад хуваарилах DV визийн тоон хязгаарыг боддог. Улс орон бүрт хувиарлагдах визийн тоо нь бүс нутагт тогтоосон хязгаар, улс орон бүрийн хөтөлбөрт оролцогчдын тоо болон оролцсон хүмүүсийн хэд нь хожигч болохоос хамаарна. Улс орон бүрийн уугуул иргэдэд нийт олгогдох визийн 7-гоос ихгүй хувь хуваарилагдана.

5. БОЛОВСРОЛ, АЖЛЫН ТУРШЛАГЫН ШАЛГУУР НЬ ЮУ ВЭ?

АНУ-ын Цагаачлалын хуульд зааснаар DV хөтөлбөрт оролцогч бүр дор хаяж ахлах сургуулийн боловсрол буюу түүнтэй адилтгах боловсролтой эсвэл сүүлийн таван жилийн хугацаанд дор хаяж хоёр жилийн сургалт, туршлага шаардах мэргэжлээр хоёр жил ажилласан туршлагатай байх ёстой. "Ахлах сургуулийн боловсрол буюу түүнтэй адилтгах боловсрол" гэдэг нь Америкийн Нэгдсэн Улсын бага болон дунд боловсролын 12 жилийн сургалтыг амжилттай дүүргэсэнтэй дүйцэх эсвэл өөр улс оронд АНУ-ын ахлах сургуулийн боловсролтой дүйцэхүйц албан ёсны бага болон дунд боловсролын сургалтыг амжилттай дүүргэсэн байхыг хэлнэ. Энэ шаардлагыг зөвхөн албан ёсны сургалт л хангах бөгөөд дүйцүүлэх буюу шилжүүлэн тооцсон сургалт эсвэл сертификатыг /G.E.D гэх мэт/ хүлээн зөвшөөрөхгүй. Боловсрол, ажлын туршлагыг нотлох баримт бичгийг визийн ярилцлагын үеэр Консулын ажилтанд өгөх ёстой.

Таны боловсрол эсвэл ажлын туршлага шаардлаганд нийцэхгүй бол та DV хөтөлбөрт оролцох боломжгүй болж таны эхнэр/нөхөр болон хүүхдүүд DV хөтөлбөрт гэр бүлийн гишүүнээр оролцох эрхгүй болно.

6. DV ХӨТӨЛБӨРТ ЯМАР МЭРГЭЖЛҮҮД ТЭНЦЭХ ВЭ?

Ажлын туршлага дээр суурилсан болзлыг хангах шалгуурыг тодорхойлоход АНУ-ын Хөдөлмөрийн яамны [O*Net Online](#) мэдээллийн санг ашигладаг. [O*Net Online](#) мэдээллийн сан ажлын туршлагыг таван "мэргэжлийн бүсэд" ангилсан. Хөдөлмөрийн яамны цахим хуудсанд олон мэргэжлийг жагсаасан байдаг ч Олон үндэстний визийн хөтөлбөрт зөвхөн тодорхой мэргэжлүүд тэнцэнэ. Ажлын туршлагаараа Олон үндэстний визийн шалгуурт тэнцэхийн тулд та өнгөрсөн таван жилийн хугацаанд Мэргэжлийн тусгай бэлтгэлийн (SVP) 7.0 буюу түүнээс дээш зэрэглэлтэй 4, 5 дугаар мэргэжлийн бүсэд багтсан мэргэжлээр хоёр жил ажилласан туршлагатай байх ёстой.

Таны боловсрол эсвэл ажлын туршлага шаардлаганд нийцэхгүй бол та DV хөтөлбөрт оролцох боломжгүй болж таны эхнэр/нөхөр болон хүүхдүүд DV хөтөлбөрт гэр бүлийн гишүүнээр оролцох эрхгүй болно.

7. БИ ХЭРХЭН ХӨДӨЛМӨРИЙН ЯАМНЫ ЦАХИМ ХУУДСААС ШАЛГУУРТ ТЭНЦЭХ МЭРГЭЖЛҮҮДИЙГ ОЛОХ ВЭ?

Таны мэргэжил шалгуурт тэнцэх эсхийг мэдэхийн тулд [O*Net Online](#) мэдээллийн санд орж дараах зааврыг харна уу:

1. "Find Occupations" (Мэргэжил ол) гэснийг сонгоод дараа нь "Job Family" гэснийг сонго;
2. "Job Family" дотроос өөрийн мэргэжлийн холбоосыг сонгож "GO" товчийг дарна;
3. Нэг мэргэжлийг сонгоно;
4. "Job Zone" (Мэргэжлийн бүс) гэснийг дарж Мэргэжлийн бүсийн дугаар, Мэргэжлийн тусгай бэлтгэл (SVP)-ийн зэрэглэлээ олж мэднэ.

Жишээлбэл: "Aerospace Engineers" (Сансрын хөлгийн инженер) гэснийг сонгоё. Мэргэжлийн бүс хэсгийн сансрын хөлгийн инженер гэсэн мэргэжлийн дор Мэргэжлийн бүс 4, Мэргэжлийн тусгай бэлтгэл 7.0<8.0 гэсэн тайлбар харагдана. Тайлбарын дагуу сансрын хөлгийн инженер нь шалгуурт тэнцэж байна.

Нэмэлт мэдээллийг [Diversity Visa – List of Occupations webpage](#) хуудаснаас харна уу.

8. E-DV ХӨТӨЛБӨРТ ОРОЛЦОХ НАСНЫ ДООД ХЯЗГААР БАЙДАГ УУ?

Тус хөтөлбөрт оролцох насны доод хязгаарыг заагаагүй боловч гол бүртгүүлэгч бүртгүүлэх үедээ ахлах сургуулийн боловсролтой буюу ажлын туршлагатай байхыг шаарддаг тул 18-аас доош насны ихэнх хүмүүс энэ шалгуурт тэнцэхгүй.

DV ХӨТӨЛБӨРИЙН ЭЛЕКТРОН БҮРТГЭЛ

9. БИ ХЭЗЭЭ ХӨТӨЛБӨРТ БҮРТГҮҮЛЖ БОЛОХ ВЭ?

DV-2022 хөтөлбөрт оролцох бүртгэл 2020 оны 10 сарын 7-ны Лхагва гаригийн АНУ-ын Зүүн эргийн өдрийн цагийн бүсийн (EDT) (GMT-4) үдийн 12.00 цагаас 2020 оны 11 сарын 10-ны Мягмар гаригийн АНУ-ын Зүүн эргийн стандарт цагийн бүсийн (EST) (GMT-5) үдийн 12.00 цагийн хооронд үргэлжилнэ. Жил бүр бүртгэлийн хугацаанд олон сая хүн хөтөлбөрт оролцдог. Бүртгэлийн хугацааг ингэж заагласнаар хожсон хүмүүс зохих хугацаанд нь мэдээлэлээ олж авах, түүнчлэн виз мэдүүлэгчид болон Элчин Сайдын Яам, Консулын газруудын аль алинд нь виз мэдүүлэхэд бэлтгэх, хянан шийдвэрлэхэд хугацаа олгож байгаа юм.

Танд бүртгэлийн хугацааны дотор аль болох эрт бүртгүүлэхийг зөвлөж байна. Бүртгэлийн хугацааны сүүлээр ачаалал ихэсдэгээс шалтгаалж системийн хурд удааширч болно. 2020 оны 11 сарын 10-ны Мягмар гаригийн АНУ-ын Зүүн эргийн стандарт цагийн бүсийн (EST) үдийн 12.00 цагаас хойш ямар ч бүртгэл хүлээн авахгүй.

10. БИ ОДОО АНУ-Д БАЙГАА, ХӨТӨЛБӨРТ ОРОЛЦОЖ БОЛОХ УУ?

Тийм, бүртгүүлэгч нь АНУ буюу өөр улсад байж болно. Мөн АНУ-аас буюу гадаадаас бүртгүүлж болно.

11. БҮРТГЭЛИЙН ХУГАЦААНД БИ НЭГ Л УДАА ОРОЛЦОХ ЭРХТЭЙ ЮУ?

Тийм, бүртгэлийн хугацааны турш хүн бүр нэг л удаа бүртгүүлэхийг хуулиар зөвшөөрсөн. Төрийн департамент бүртгэлийн хугацааны турш олон бүртгэл оруулсан хүмүүсийг илрүүлэх боловсронгуй технологи ашигладаг. **Хэрэв та нэгээс олон удаа бүртгүүлбэл DV хөтөлбөрт оролцох боломжгүй болно.**

12. DV ХӨТӨЛБӨРТ ОРОЛЦОХЫН ТУЛД ЯАГААД ПАСПОРТТАЙ БАЙХ ЁСТОЙ ВЭ? ЭНЭ ШААРДЛАГААС ЧӨЛӨӨЛӨГДӨХ БОЛОМЖ БАЙГАА ЮУ?

Хүчинтэй, хугацаа нь дуусаагүй паспортын мэдээлэл оруулсанаар таны DV бүртгэлийн аюулгүй байдлыг нэмэгдүүлнэ. Энэхүү шаардлага нь үндсэн оролцогчдод л хамааралтай бөгөөд гэр бүлийн гишүүдэд хамааралгүй болно. Таны паспорт гадаадад аялах хүчинтэй байх хэрэгтэй.

Шаардлагаас чөлөөлөгдөх нөхцөлүүд: Төрийн департаментийн дүрмийн дагуу үндсэн гурван нөхцөлөөр паспорттай байх шаардлагаас чөлөөлөгдөнө. Үүнд улс орны харъяалалгүй хувь хүн, паспорт авах боломжгүй Коммунист засгийн эрхтэй улсын иргэн эсвэл Төрийн департаментийн Дотоодын аюулгүй байдлын яамнаас тусгай зөвшөөрөл авсан хувь хүн багтана.

13. ВИЗ МЭДҮҮЛЭХЭЭС ӨМНӨ ПАСПОРТНЫ ХУГАЦАА ДУУСАХ ЭСВЭЛ ПАСПОРТОО АЛГА БОЛГОСОН ТОХИОЛДОЛД ЯАХ ВЭ?

Таны паспортын дугаар ямар нэгэн байдлаар өөрчлөгдвөл Төрийн департаментийн Kentucky Consular Center (КСС)-д ярилцлага товлороос өмнө яагаад өөрчлөгдсөн нотолгоог өгөх хэрэгтэй. Хэрэв та хуурамч, алдаатай эсвэл хүчингүй паспортын мэдээлэл оруулбал та DV хөтөлбөрт оролцох боломжгүй болно. Хөтөлбөрт мэдүүлсэн паспортны хуулбарыг бүртгэл баталгаажсан дугаартай хамт найдвартай газар хадгалахыг зөвлөж байна (Түгээмэл асуулт №27). Ганц паспортны хуулбараар хүчинтэй паспортны дугаар оруулсан эсэхийг нотлохгүй ч нөхцөл байдлыг тайлбарлахад нэмэр болно. Эцсийн шийдвэрийг визийн ярилцлаган дээр Консул гаргана.

14. БИ ЭХНЭР/НӨХӨРТӨЙГӨӨ ТУСДАА ОРОЛЦОЖ БОЛОХ УУ?

Тийм, эхнэр нөхөр хоёр хоюулаа шалгуурт тэнцэж байвал тус тусдаа бүртгүүлж оролцож болно. Аль нэг нь сонгогдсон тохиолдолд нөгөөх нь дагаж явах эрхтэй.

15. E-DV БҮРТГЭЛД БИ ГЭР БҮЛИЙНХЭЭ ЯМАР ГИШҮҮДИЙГ ОРУУЛАХ ЁСТОЙ ВЭ?

Эхнэр/нөхөр: Та өөрийн эхнэр/нөхөртөйгөө хууль ёсны дагуу гэрлэсэн бол одоогоор тантай хамт амьдардаг амьдардаггүй, тантай хамт цагаачлах цагаачлахгүй гэдгээс үл хамааран эхнэр/нөхрөө заавал бүртгэлд оруулах ёстой. Та эхнэр/нөхрөөсөө албан ёсны бичгэн шүүхийн шийдвэрийн дагуу тусдаа амьдардаг тохиолдлоос бусад үед эхнэр/нөхрөө заавал оруулах ёстой. Хуулийн дагуу тусдаа амьдардаг тохиолдол нь гэрлэсэн хэвээрээ хэдий ч шүүхийн шийдвэрийн дагуу тусдаа амьдрахыг хэлнэ. Хэрэв та эхнэр/нөхрөөсөө хуулийн дагуу тусдаа амьдардаг бол таны эхнэр/нөхөр таныг дагаж DV хөтөлбөрт хамрагдан цагаачлах боломжгүй. Та хуулийн дагуу тусдаа амьдардаг эхнэр/нөхрийнхөө нэрийг бүртгэлийн хуудсан дээрээ оруулсан тохиолдолд ямар нэгэн асуудал үүсэхгүй. Харин та DV хөтөлбөр эхлэхээс өмнө гэрлэлтээ цуцлахаар төлөвлөсөн хэдий ч тусдаа амьдардаг гэсэн шүүхийн шийдвэр байхгүй бол эхнэр/нөхрөө заавал оруулах ёстой. Хуулийн дагуу гэрлэсэн эхнэр/нөхрөө бүртгэлийн хуудсан дээрээ оруулаагүй эсвэл эхнэр/нөхөр болоогүй хүнийг оруулсан тохиолдолд та DV хөтөлбөрт оролцох боломжгүй болно. Хөтөлбөрт бүртгүүлж байгаа хугацаанд гэрлэлтээ батлуулаагүй байгаа хэрнээ ирээдүйд батлуулах төлөвлөгөөтэй байгаа тохиолдолд сүйт бүсгүй/сүйт залуугаа бүртгэлийн хуудсан дээр оруулбал мөн адил DV хөтөлбөрт оролцох боломжгүй болно. Та гэр бүлээ цуцлуулсан эсвэл таны эхнэр/нөхөр нас барсан бол хуучин эхнэр/нөхрөө бичих шаардлагагүй.

Хэрэв таны эхнэр/нөхөр АНУ-ын иргэн эсвэл Хууль ёсны байнгын оршин суугчид бүртгэлийн хуудсан дээр оруулж болохгүй. Учир нь АНУ-ын иргэн эсвэл Хууль ёсны байнгын оршин суугч бол виз авах шаардлагагүй юм. Энэ тохиолдолд та бүртгэлийн хуудсан дээрээ “гэрлэсэн бөгөөд миний эхнэр/нөхөр АНУ-ын иргэн эсвэл хууль ёсны байнгын оршин суугч” сонголтыг сонгоход систем таниас таны эхнэр/нөхрийн талаар нэмэлт мэдээлэл шаардахгүй болно.

Хүүхэд: Та гэрлээгүй бөгөөд хөтөлбөрт бүртгүүлэх үед тань 21 нас хүрээгүй байсан бүх төрсөн хүүхдүүд, эхнэр/нөхрийнхөө хүүхдүүд (тухайн хүүхдийн эцэг/эхээс салсан байсан ч), зохих хуулийн дагуу албан ёсоор үрчилж авсан хүүхдүүдээ АНУ-ын иргэн болон хууль ёсны байнгын оршин суугч биш л бол DV хөтөлбөрт анх оролцох үедээ багтаах ёстой. Таны хүүхдүүд тантай хамт амьдрахаа больсон, таныг дагаж цагаачлахгүй байсан ч бүртгэлд оруулах хэрэгтэй. Хэрэв таны хүүхэд АНУ-ын иргэн эсвэл Хууль ёсны байнгын оршин суугч бол та бүртгэлийн хуудсан дээр оруулах шаардлагагүй бөгөөд оруулсан тохиолдолд асуудал үүсэхгүй.

Хөтөлбөрт бүртгүүлж байгаа хүний эцэг эх болон төрсөн ах эгч дүү нар бүртгүүлж байгаа хүнийг дагалдан DV виз авах боломжгүй бөгөөд тэднийг бүртгэлд оруулах шаардлагагүй.

Та гэр бүлийнхээ гишүүдийг бүртгэлд оруулсан нь тэд тантай заавал хамт виз мэдүүлж эсвэл цагаачилж эсвэл хамт явах ёстой гэсэн үг биш. Харин та анх хөтөлбөрт бүртгүүлэхдээ бүртгүүлэх ёстой

байсан гэр бүлийн гишүүнээ оруулаагүй эсвэл гэр бүлийн гишүүн бус хүнийг оруулсан тохиолдолд та DV хөтөлбөрт оролцох боломжгүй болж таны эхнэр/нөхөр болон хүүхдүүд DV хөтөлбөрт гэр бүлийн гишүүнээр оролцох эрхгүй болно. Энэ нь анх бүртгүүлэх үед гэр бүлийн гишүүн байсан хүмүүст л хамаатай бөгөөд сүүлд шинээр нэмэгдсэн гэр бүлийн гишүүдэд хамаагүй. Таны эхнэр/нөхөр таны бүртгэлд орсон ч гэсэн тусдаа бүртгүүлж болно. Гол нь хоёр бүртгэлдээ хоёуланд нь бүртгүүлэх ёстой гэр бүлийнхээ бүх гишүүдийн тухай мэдээллийг оруулах ёстой. (Энэ талаарх нэмэлт мэдээллийг Түгээмэл асуулт №12-оос үзнэ үү).

16. БИ ЗААВАЛ ӨӨРӨӨ БҮРТГҮҮЛЭХ ЁСТОЙ ЮУ ЭСВЭЛ ХЭН НЭГ ХҮН МИНИЙ ӨМНӨӨС БҮРТГҮҮЛЖ БОЛОХ УУ?

Танд бүртгэлээ өөрөө хийхийг зөвлөж байна. Гэхдээ өөр хүнээр бүртгүүлүүлж болно. Өөрөө шууд бүртгүүлсэн ч бай, өмгөөлөгч, таньдаг хүн, төрөл садныхаа хүнээс тусламж авсан ч бай хүн бүрийн нэр дээр нэг л бүртгэл оруулах ёстой бөгөөд бүртгэл дээрх мэдээллийн үнэн зөв, бүрэн эсэхийг бүртгүүлэгч өөрөө хариуцна гэдгийг санаж байх ёстой. Оролцогчид өөрсдийн бүртгэлийн баталгаажсан дугаарыг хадгалах ёстой бөгөөд энэ дугаарын тусламжтайгаар dvprogram.state.gov руу орж ENTRANT STATUS CHECK-ээр бүртгэлийнхээ явцыг өөрөө шалгана. Оролцогчид E-DV бүртгэлийн маяганд бүртгүүлсэн имэйлээ шалгах мэдээллийг өөрт хадгалах хэрэгтэй.

17. БИ ӨӨР ТӨРЛИЙН ЦАГААЧЛАЛЫН ВИЗЭНД БҮРТГҮҮЛСЭН БАЙГАА ХЭДИЙ Ч DV ХӨТӨЛБӨРТ ОРОЛЦОЖ БОЛОХ УУ?

Тийм.

18. E-DV БҮРТГЭЛИЙН МАЯГТЫГ MICROSOFT WORD ПРОГРАМ (БУЮУ БУСАД ТОХИРОМЖТОЙ ПРОГРАМ РУУ) ТАТАН АВЧ ХАДГАЛААД ДАРАА НЬ БӨГЛӨЖ БОЛОХ УУ?

Үгүй, та энэ маягыг сүүлд бөглөж өгөхөөр өөр програмд хадгалах боломжгүй. E-DV бүртгэлийн маягт нь зөвхөн онлайн бөглөдөг маягт юм. Тиймээс та тус маягыг бөглөхдөө онлайнаар мэдээллээ оруулж, илгээх шаардлагатай.

19. БҮРТГЭЛИЙН МАЯГТЫН НЭГ ХЭСГИЙГ НЬ БӨГЛӨӨД ИНТЕРНЕТЭД ХАДГАЛЖ ДАРАА НЬ ЭРГЭЖ ОРООД ГҮЙЦЭЭН БӨГЛӨЖ БОЛОХ УУ?

Үгүй. E-DV бүртгэлийн маягыг нэгмөсөн бөглөж оруулахаар зохиосон. Та маягыг татаж авахаас эхлээд бүртгэлийг интернетээр оруулж E-DV цахим хуудас дээр хүлээн авах хүртэлх нийт хугацаа жаран (60) минут байхаар E-DV системийг бүтээсэн. Жараас илүү минут өнгөрч мөн бүртгэл электрон хэлбэрээр орж амжаагүй бол оруулсан бүх мэдээлэл хүчингүй болно. Ингэснээр бүтэн оруулсан бүртгэл нь өмнө хагас дутуу оруулсан бүртгэлийн хуулбар байна гэж ойлгогдох эрсдлээс сэргийлж байгаа юм. Маягт

бөглөж эхлэхээсээ өмнө хэрэгтэй бүх мэдээллээ бэлдэж, бүрэн бэлтгэлтэй байхын тулд DV бүртгэлийн зааварчилгааг уншиж танилцана уу.

20. ХЭРЭВ НАДАД СКАЙНЕР БАЙХГҮЙ БОЛ БИ ЗУРГАА АНУ-Д БАЙДАГ ХАМААТАН РУУГАА ЯВУУЛААД СКАЙНЕРДУУЛЖ, ДИСКЭНД БУУЛГУУЛААД ТЭР ДИСКИЙГ ШУУДАНГААР АВААД БҮРТГҮҮЛЖ БОЛОХ УУ?

Тийм, гэрэл зураг тань энэхүү зааварчилгаан дээр байгаа гэрэл зурагт тавих шаардлагыг хангаж байгаа бөгөөд E-DV онлайн бүртгүүлэхдээ тэр зургаа электрон хэлбэрээр оруулж чадвал болно. Интернетээр бүртгүүлэхээсээ өмнө бэлэн скайнердсан гэрэл зургийн файлтай байх ёстой. Гэрэл зургаа онлайн бүртгэлээсээ тусад нь оруулж болохгүй. Та хөтөлбөрт АНУ эсвэл бусад гадаад улсаас бүрэн электрон хэлбэрээр (гэрэл зураг, бүртгэлийг хамтад нь) бүртгүүлж болно.

21. ХЭВЭР E-DV БҮРТГЭЛИЙН СИСТЕМ МИНИЙ БҮРТГЭЛИЙГ ТАТГАЛЗВАЛ, БИ БҮРТГЭЛЭЭ ДАХИН ОРУУЛЖ БОЛОХ УУ?

Тийм, та 2020 оны 11 дүгээр сарын 10-ны Мягмар гаригийн АНУ-ын Зүүн эргийн стандарт цагийн бүсийн (EST) (GMT-5) үдийн 12.00 цагаас өмнө бүртгэлээ дуусгаж дахин оруулж болно. E-DV систем таныг хүлээж аваагүй тохиолдолд дахин бүртгэлд оруулахад ямар нэгэн асуудал үүсэхгүй. Татгалзсан тухай мэдээ ирэх хүртэл зарцуулагдах хугацаа тухайн интернетийн хурдаас хамаарах тул урьдчилан хэлэх аргагүй юм. Систем гүйцэд бөглөсөн бүртгэл хүлээн авч, баталгаажсан мэдэгдэл илгээх хүртэл хэдэн ч удаа бүртгүүлэхийг оролдож болно. Баталгаажсан мэдэгдлийг хүлээн авсны дараа дахин нэмэлт бүртгэл хийх ёсгүй.

22. БҮРТГЭЛИЙГ ИЛГЭЭСНИЙ ДАРАА ОНЛАЙН СИСТЕМ ХҮЛЭЭН АВСНЫГ НОТЛОХ ЭЛЕКТРОН МЭДЭГДЛИЙГ ХЭР ХУРДАН ХҮЛЭЭЖ АВАХ ВЭ?

E-DV цахим хуудас электрон мэдэгдлийг хадгалж авах шаардлагатай баталгаажсан дугаарын хамт тэр даруй явуулдаг. Гэхдээ энэ нь бүртгүүлэгчид хэр удаж хүрэхийг тухайн интернетийн хурд, имэйлийн системээс шалтгаалан урьдчилан таамаглах аргагүй. Та 'Submit' (Оруул) товчийг онлайн систем таны бүртгэлийг хүлээн авч танд электрон мэдэгдэл ирэх хүртэл хэдэн ч удаа дарж болно. Харин бүртгэлийг баталгаажуулсан хуудсыг хүлээн авсны дараа 'Submit' (Оруул) товчийг дахин дарж болохгүй.

23. БИ 'SUBMIT' (ОРУУЛ) ТОВЧИЙГ ДАРСАН ХЭДИЙ Ч БАТАЛГААЖСАН ДУГААР ХҮЛЭЭН АВААГҮЙ ТОХИОЛДОЛД ДАХИН БҮРТГЭЛ ИЛГЭЭВЭЛ МИНИЙ БҮРТГЭЛ ХҮЧИНГҮЙ БОЛОХ УУ?

Баталгаажсан дугаар хүлээж аваагүй тохиолдолд таны бүртгэл бүртгэгдээгүй гэсэн үг юм. Тиймээс дахин бүртгэл илгээх хэрэгтэй бөгөөд энэ нь давхардсан ижил бүртгэлд тооцогдохгүй. Харин бүртгэлийн баталгаажуулсан хуудсыг хүлээн авсны дараа дахин бүртгэл илгээж болохгүй.

ХОЖИГЧ СОНГОХ ЯВЦ

24. БИ DV ХӨТӨЛБӨРТ СОНГОГДСОН ЭСЭХЭЭ ХЭРХЭН МЭДЭЖ БОЛОХ ВЭ?

Та онлайнаар хөтөлбөрт бүртгүүлэхэд гарч ирсэн бүртгэлийн дугаараа ашиглан 2021 оны 5 сарын 8-наас 2022 оны 9 сарын 30 хүртэл E-DV-гийн dvprogram.state.gov вэб хуудсаар орж Entrant Status Check-ээр статусаа шалгах хэрэгтэй. Entrant Status Check нь таны хөтөлбөрт шалгарсныг мэдээлэх цорын ганц арга бөгөөд визийн өргөдлөө хэрхэн үргэлжлүүлэх, визэнд орох өдөр, цаг зэргийг танд мэдээлнэ. Төрийн департамент бүх боломжит визийн тоог ашиглахын тулд Entrant Status Check-ээр дамжуулан 2021 оны 5 сарын 8-наас хойш нэмэлтээр сонгогдсон оролцогчдод мэдэгдэх боломжтой. Тиймээс та бүртгэлийн дугаараа 2022 оны 9 сарын 30 хүртэл хадгална уу. E-DV-гийн dvprogram.state.gov вэб хуудас бол DV хөтөлбөрт оролцох болон шалгарснаа мэдэх Төрийн департаментын цорын ганц албан ёсны хуудас юм.

Төрийн департамент таныг хөтөлбөрт хожсон талаар ХЭЗЭЭ Ч тантай холбоо барьж мэдээлэхгүй. (Энэ талаарх нэмэлт мэдээллийг Түгээмэл асуулт №24-өөс үзнэ үү).

25. БИ ХӨТӨЛБӨРТ СОНГОГДООГҮЙ ГЭДГЭЭ ЯАЖ МЭДЭХ ВЭ? НАДАД МЭДЭГДЭХ ҮҮ?

Та сонгогдсон тохиолдолд төрийн департаментас таньд шууд МЭДЭГДЭХГҮЙ. Зөвхөн Entrant Status Check ашиглах хэрэгтэй. Та 2021 оны 5 сарын 8-наас 2022 оны 9 сарын 30 хүртэл E-DV-гийн dvprogram.state.gov вэб хуудсаар орж Entrant Status Check-ээс шалгарсан эсэхээ мэдэх боломжтой. Та баталгаажсан бүртгэлийн дугаараа дор хаяж 2022 оны 9 сарын 30 хүртэл хадгалах хэрэгтэй. (Өмнөх жилийн DV-2020 хөтөлбөрийн статусыг 2020 оны 9 сарын 30 хүртэл шалгах боломжтой).

26. БИ БҮРТГЭЛИЙН БАТАЛГААЖСАН ДУГААРАА ГЭЭСЭН ТОХИОЛДОЛД ЯАХ ВЭ?

Та Entrant Status Check-рүү орохын тулд таны баталгаажсан дугаар хэрэг болно. E-DV цахим хуудасны Entrant Status Check дотор баталгаажсан дугаараа сэргээж авах шинэ систем бий болсон. Үүний тулд та өөрийгөө батлах хувийн мэдээллийг оруулсанаар хөтөлбөрт бүртгүүлэхэд оруулсан имэйл хаяг руу тань таны баталгаажсан дугаар илгээгдэх болно.

Та зөвхөн Entrant Status Check-ийн баталгаажсан дугаар сэргээх систем ашиглан өөрийн дугаараа авах боломжтой бөгөөд АНУ-ын ЭСЯам, Консулын газрууд болон Кэнтаки дахь Консулын Төв нь DV хөтөлбөрийн статус шалгах системд орж таны баталгаажсан дугаарыг гаргаж өгөх боломжгүй юм. Мөн Төрийн департамент хөтөлбөрт хожсон визэнд орох хүмүүсийн жагсаалтыг гаргаж өгөхгүй.

27. БИ ТӨРИЙН ДЕПАРТАМЕНТААС ИМЭЙЛ ЭСВЭЛ ШУУДАНГААР МЭДЭГДЭЛ ХҮЛЭЭЖ АВАХ УУ?

Төрийн департаментаас танд мэдэгдэл захиа явуулахгүй. АНУ-ын Засгийн газар шалгарсан хүмүүст хэзээ ч имэйл явуулж байгаагүй бөгөөд DV-2022 хөтөлбөрт ч имэйл ашиглах төлөвлөгөө байхгүй. Та шалгарсан тохиолдолд заавал эхэлж Entrant Status Check -ийн зааварт хариу өгч таны цаашдын процесс эхэлсний дараа л имэйл хүлээн авна. Энэ имэйл нь таныг Entrant Status Check рүү орж визэнд орох өдөр, цагаа мэдэхийг зөвлөх ба тухайн визийн ярилцлага хийх өдөр цагийн талаарх мэдээллийг агуулахгүй. Төрийн департаментаас DV хөтөлбөрийн оролцогчдод Entrant Status Check рүү орж өөрсдийн статусыг шалгах санамж имэйл илгээх боломжтой. Ийм төрлийн имэйл нь хөтөлбөрт оролцогчдын сонгогдсон эсэх талаархи мэдээллийг хэзээ ч агуулахгүй болно.

Та ".gov" төгсгөл бүхий хаягтай цахим хуудаснууд л АНУ-ын засгийн газрын албан ёсны интернэт цахим хуудас гэдгийг анхаарна уу. Засгийн газрын бус олон цахим хуудас (жишээлбэл, ".com", ".org", ".net" зэрэг төгсгөлтэй цахим хуудаснууд) цагаачлал болон визтэй холбоотой мэдээлэл өгч, үйлчилгээ үзүүлдэг. Агуулгаас нь үл хамааран Төрийн департамент эдгээр засгийн газрын бус цахим хуудаснуудын аливаа мэдээлэл, материалыг баталж, санал болгож, ивээн тэтгэдэггүй.

Зарим цахим хуудас өөрсдийгөө албан ёсны цахим хуудас гэж олон нийт, үйлчлүүлэгчдэд итгүүлж төөрөгдүүлэхийг хичээн таныг төлбөр төлөх эсвэл хувийн мэдээллээ явуулахыг шаардах магадлалтай. Эдгээр цахим хуудас Төрийн департаментын цахим хуудас, travel.state.gov болон АНУ-ын ЭСЯ/Консулын газрын цахим хуудаснаас үнэ төлбөргүй авч болох цагаачлалын талаарх мэдээлэл болон маягт зэргийг танд санал болгохдоо төлбөр төлөхийг шаарддаг. Үүний зэрэгцээ эдгээр цахим хуудас нь таны мөнгийг шууд залилж авахын тулд DV визтэй холбогдох үйлчилгээний хөлсийг танаас нэхэж болно. Та эдгээр төрийн бус байгууллага эсвэл цахим хуудас руу мөнгөө явуулбал эргүүлж авах магадлал маш бага гэдгийг анхаарна уу. Хувийн мэдээллийг тань залилан/хулгайн гэмт хэрэгт ашиглаж болох тул эдгээр цахим хуудсанд хувийн мэдээллээ дамжуулахаас болгоомжлоорой.

Ийм төрлийн имэйл явуулж буй хүмүүс өөрсдийгөө Төрийн департамент эсвэл Кэнтаки дахь Консулын Төвтэй хамтран ажилладаг хэмээн хуурамч мэдээлэл өгөх тохиолдол байдаг. **АНУ-ын засгийн газраас хөтөлбөрт оролцогчдод хэзээ ч хөтөлбөрт сонгогдсон талаар имэйл явуулж байгаагүй бөгөөд DV-2022 хөтөлбөрт ийм төрлийн имэйл явуулах төлөвлөгөө байхгүй болохыг сануулж байна. Мөн түүнчлэн Төрийн департамент таниас хэзээ ч шуудан эсвэл бусад Western Union гэх мэт үйлчилгээ ашиглан мөнгө илгээхийг шаардахгүй.**

28. DV-2022 ХӨТӨЛБӨРТ ХЭДЭН ХҮН СОНГОГДОХ ВЭ?

DV-2022 хөтөлбөрөөр нийт 55,000 DV виз өгөх боломжтой. Сонгогдсон эхний 55,000 хүнээс визийн шалгуурт тэнцэхгүй хүмүүс болон визээ мэдүүлэхгүй орших хүмүүс ч гарна. Гэхдээ энэ нь нөгөө талаар анх сонгогдсон бүх хүнд хүрэлцэхүйц тооны виз байна гэсэн үг биш.

Та E-DV цахим хуудасны ENTRANT STATUS CHECK рүү орж өөрийн шалгарсан эсэх мөн жагсаалтад өөрийнхөө хаана байгаа дарааллыг харах боломжтой. DV-2022 хөтөлбөрийн визийн ярилцлага 2020

оны 10 дугаар сард эхэлнэ. Үүнд зааварчилгаа мэдэгдлийн дагуу баримт бичгээ бүрдүүлж өгсөн хүмүүс оролцоно. Бүх шаардлагатай баримт бичгийг бүрдүүлж өгөн шалгарсан хүмүүст E-DV цахим хуудасны ENTRANT STATUS CHECK-ээс АНУ-ын Консулын хэлтэст болох визийн ярилцлага өгөх өдөр цагийг хуваарьт өдрөөс 4-6 долоо хоногийн өмнө мэдэгдэнэ.

Сар бүр визийн байгаа дугаараас хамааран тухайн сард виз авахад бэлэн шалгарсан хүмүүст виз олгоно. Бүх 55,000 олон үндэстний (DV) виз олгогдож дууссанаар тухайн жилийн хөтөлбөр дуусна. Энэ нь бүх виз олгогдсон тохиолдолд хөтөлбөр 2022 оны 9 сараас өмнө дуусах боломжтой гэсэн үг юм. Шалгарсан хүмүүс визээ авахыг хүсвэл хурдан шуурхай хөөцөлдөхөд бэлэн байх ёстой. **Компьютерээр хийдэг санамсаргүй сонголтонд шалгарснаар та автоматаар виз авах баталгаатай боллоо гэж бодож болохгүй. Хөтөлбөрт шалгарна гэдэг нь та DV виз хүсэх эрхтэй болсон бөгөөд танай бүсэд танд олгох боломжтой визийн тоо байгаа тохиолдолд дараагийн шат руу шилжинэ гэсэн үг юм. Эдгээр оролцогчдоос зөвхөн 55,000-д нь виз олгогдох юм.**

29. АМЖИЛТТАЙ БҮРТГҮҮЛСЭН ОРОЛЦОГЧДЫГ ХЭРХЭН СОНГОХ ВЭ?

Албан ёсны мэдэгдэл 2021 оны 5 сарын 8-наас эхлэн 2022 оны 9 сарын 30-ны хооронд E-DV-гийн dvprogram.state.gov вэб хуудасны Entrant Status Check дээр гарна. Төрийн департамент хөтөлбөрт шалгарсан хүмүүст шалгарсныг нь имэйл эсвэл шуудангаар захидал илгээдэггүй. Хэрэв танд хөтөлбөрт шалгарсан талаар имэйл эсвэл шуудангаар захидал ирвэл хууль бус гэдгийг анхаараарай. Та шалгарлаа гэхэд та өөрөө заавал эхэлж Entrant Status Check рүү орж шалгаад заасан зааварт хариу өгч таны цаашдын процесс эхэлсний дараа л Төрийн департаментас танд Entrant Status Check рүү орж шинэ мэдээлэл шалгах талаар зөвлөсөн зааварчилгааг имэйлээр өгнө. Төрийн департамент хэзээ ч танд шуудангаар юм уу Western Union гэх мэт аргаар төлбөр гуйвуулах хүсэлт тавихгүй.

Газарзүйн бүс тус бүрээс ирсэн бүх бүртгэлийг нэгбүрчлэн дугаарлана. Бүртгэлийн хугацаа дууссаны дараа компьютер газарзүйн бүс бүрээс хүлээн авсан бүх бүртгэлээс санамсаргүй байдлаар сонголт хийнэ. Бүс бүрээсээ санамсаргүй байдлаар сонгогдсон эхний бүртгэл нэгт, хоёр дахь бүртгэл хоёрт гэх мэтчилэн бүртгэгдэнэ. Хугацаанд нь амжилттай илгээсэн бүх бүртгэл бүсийнхээ хүрээнд сонгогдох магадлал нь ижил байна. Компьютер аль нэг бүртгэлийг сугалж гаргасны дараа E-DV-гийн dvprogram.state.gov вэб хуудасны Entrant Status Check-ээс тухайн шалгарсан оролцогч 2021 оны 5 сарын 8-наас эхлэн шалгарсан эсэхээ мэдэх болно. Шалгарсан хүмүүс АНУ-ын ЭСЯ/Консулын газарт визэнд орох заавар автал, мөн статусаа өөрчлөх боломжтой болсон хүмүүс АНУ дахь АНУ-ын Иргэншил ба Цагаачлалын Алба (USCIS)-нд гаргах хүртэл Kentucky Consular Center (KCC) асуудлыг хариуцах болно.

30. БИ ОДОО АНУ-Д БАЙГАА. ХЭРЭВ СОНГОГДВОЛ СТАТУСАА ӨӨРЧЛӨХӨӨР USCIS-Д ХАНДАЖ БОЛОХ УУ?

Тийм, тэд ЦХТХ-ийн 245 дугаар зүйлд заасан нөхцлийн дагуу статусаа өөрчлөх эрхтэй бол, АНУ-д байгаа сонгогдсон хүмүүс өөрсдийн статусаа байнгын оршин суугчийн статус болгон өөрчлөхийн тулд USCIS- д хандаж болно. Та 2022 оны 9 дүгээр сарын 30-наас өмнө USCIS таны мэдүүлгийг шийдвэрлэж, АНУ-д таныг дагалдаж ирэх хүмүүсийн материалыг хянан шийдвэрлэсэн байх ёстойг анхаарна уу. Учир нь тэр өдөр таны DV-2022 хөтөлбөрт оролцох хугацаа дуусна. 2022 оны 9 дүгээр сарын 30-ны шөнө дундаас хойш ямар ч нөхцөлд DV-2022 хөтөлбөрийн виз олгохгүй.

31. ХЭРЭВ БИ СОНГОГДВОЛ, ХЭР УДААН ХУГАЦААНД DV КАТЕГОРИОР ВИЗ ХҮСЭХ ЭРХТЭЙ ВЭ?

Хэрэв та DV-2022 хөтөлбөрт сонгогдвол зөвхөн АНУ-ын Засгийн газрын 2022 оны санхүүгийн жилийн турш буюу 2021 оны 10 дугаар сарын 1-нээс 2022 оны 9 дүгээр сарын 30 хүртэлх хугацаанд виз хүсэх эрхтэй. Сонгогдсон оролцогчдыг өөрсдийн харъяалагдах бүсэд олгогдох боломжтой визийн тоо гарсны дараа визээ аль болох эрт мэдүүлэхийг зөвлөж байна.

Өргөдөл гаргагчид санхүүгийн жилийн эцэс гэхэд DV визээ авах буюу статусаа өөрчилсөн байх ёстой. Сонгогдсон боловч 2022 оны санхүүгийн жилд багтан визээ авч чадаагүй хүмүүсийн DV виз хүсэх эрхийг дараа он руу шилжүүлдэггүй. Мөн DV-2022 хөтөлбөрт хожигсдын эхнэр/нөхөр буюу хүүхдүүд 2021 оны 10 дугаар сарын 1-нээс 2022 оны 9 дүгээр сарын 30 хүртэлх хугацаанд л DV виз авах боломжтой. Гадаадаас бүртгэл хийсэн хүмүүст Төрийн департаментас ярилцлага болох өдрөөс 4-6 долоо хоногийн өмнө ярилцлагын цагийг ENTRANT STATUS CHECK –ээр дамжуулж мэдэгдэнэ.

32. E-DV-Д СОНГОГДСОН ХҮН НАС БАРВАЛ DV ВИЗИЙН АСУУДАЛ ЮУ БОЛОХ ВЭ?

Хөтөлбөрт сонгогдсон хүн АНУ руу явахаас өмнө нас барсан эсвэл статусаа өөрчилсөн тохиолдолд тухайн DV бүртгэл автоматаар хүчингүй болно. Нас барсан хүний эхнэр/нөхөр, хүүхдүүд тухайн хожлоор DV виз авах эрхгүй болно. Олгогдсон бүх визийг хүчингүй болгоно.

ТӨЛБӨР

33. E-DV ХӨТӨЛБӨРТ ОРОЛЦОХОД ХЭДЭН ТӨГРӨГ ТӨЛӨХ ВЭ?

Одоогоор электрон хөтөлбөрт бүртгүүлэхэд ямар ч хураамж төлөхгүй. Гэхдээ та хөтөлбөрт сонгогдож DV визийн мэдүүлэг өгөх үедээ шаардлагатай бүх визийн хураамжийг тухайн АНУ-ын ЭСЯ/Консулын газрын кассанд шууд тушаах ёстой. АНУ-д оршин суугаа оролцогчид болон статусаа өөрчлүүлэхээр өргөдөл гаргасан хүмүүс төлбөрөө USCIS-д шууд төлнө. Хөтөлбөрт шалгарсан хүмүүст E-DV dvprogram.state.gov вэб хуудасны Entrant Status Check-ээр DV визийн талаарх өргөдлийн хураамжтай холбоотой мэдээлэл зааварчилгааг илгээдэг.

34. ХЭРЭВ БИ СОНГОГДВОЛ DV БОЛОН ЦАГААЧЛАЛЫН ВИЗИЙН ТӨЛБӨРИЙГ ХААНА ЯАЖ ТӨЛӨХ ВЭ?

Та хөтөлбөрт сонгогдсоны дараа dvprogram.state.gov вэб хуудасны Entrant Status Check-ээр дамжуулан DV визийн өргөдөл мэдүүлэх зааварчилгаа авна. Та DV визийн өргөдөл өгөх үедээ шаардлагатай бүх визийн хураамжийг АНУ-ын ЭСЯ/Консулын газарт биечлэн тушаах ёстой.

Консулын касс төлбөр хүлээн авсныг нотлох баримтыг мөнгө төлсөн даруйд таньд өгнө. Хэрэв та АНУ-ын ЭСЯ/Консулын газарт цагаачлалын виз мэдүүлж байгаа бол DV визийн хураамжийн төлбөрийг шуудан, Western Union, эсвэл бусад хүргэлтийн үйлчилгээг ашиглан хэнд ч илгээх ёсгүй. Хэрэв та сонгогдсон бөгөөд АНУ-д оршин суудаг мөн USCIS-д өргөдөл гаргаж статусаа өөрчлүүлэх гэж байгаа

бол dvprogram.state.gov вэб хуудасны Entrant Status Check дотор DV визийн төлбөрийг АНУ-ын банк руу хэрхэн илгээх тусдаа зааварчилгаатай танилцана уу.

35. БИ ХӨТӨЛБӨРТ ШАЛГАРААД ВИЗЭЭ ХҮССЭН БОЛОВЧ ВИЗИЙН ШАЛГУУР ХАНГААГҮЙ ҮНДЭСЛЭЛЭЭР ТАТГАЛЗСАН ХАРИУ АВБАЛ ВИЗИЙН ТӨЛБӨРӨӨ ЭРГҮҮЛЭН АВЧ БОЛОХ УУ?

Үгүй. Визийн төлбөр эргэн олгогдохгүй. DV виз мэдүүлэгчид виз авах бүх шалгуурыг хангах хэрэгтэй. Хэрэв тухайн виз мэдүүлэгч виз авах шалгуур хангаагүй эсвэл АНУ-ын Цагаачлалын хуулийн шалгуурт тэнцэхгүй гэж үзвэл виз олгохоос татгалзах ба визийн төлбөрийг буцаан олгохгүй.

ШАЛГУУР ХАНГАХГҮЙ БАЙХ

36. DV ХҮСЭГЧИД ВИЗИЙН ШАЛГУУР ХАНГАХГҮЙ БАЙГАА ЯМАР НЭГ ҮНДЭСЛЭЛЭЭС ЧӨЛӨӨЛӨГДӨХ ҮҮ? ИЙНХҮҮ ЧӨЛӨӨЛӨГДӨХ ХҮСЭЛТ ГАРГАВАЛ ТУСГАЙЛАН АВЧ ҮЗЭХ ҮҮ?

Үгүй. Цагаачлал, харьяаллын тухай хуульд заасан цагаачлалын виз авах шалгуур хангахгүй байх бүх үндэслэл өргөдөл гаргагчдад хамаатай байх болно. Тус хуульд визийн шалгуур хангахгүй байгаа ямар нэгэн үндэслэлээс чөлөөлөх тусгай заалтууд байхгүй бөгөөд ийнхүү чөлөөлөгдөх хүсэлтийг тусгайлан авч үздэг журам байхгүй. АНУ-ын иргэн буюу Хууль ёсны байнгын оршин суугч гадаадын иргэний ойрын хамаатантай хүмүүст хамаатай хөнгөлөх заалт DV өргөдөл гаргагчид хамаатай байж болох боловч DV хөтөлбөрийн цаг хугацааны шахуу байдлаас хамаарч иймэрхүү заалт ач холбогдлоо өгөх нь бага байх магадлалтай.

DV ХӨТӨЛБӨРТӨЙ ХОЛБОГДОХ ХУУРАМЧ МЭДЭЭЛЭЛ БОЛОН ЛУЙВРЫН АЖИЛЛАГАА

37. ИНТЕРНЕТИЙН ЗАЛИЛАН БУЮУ ХҮСЭЭГҮЙ ИМЭЙЛИЙН ТАЛААР ХЭРХЭН МЭДЭЭЛЭХ ВЭ?

Холбооны худалдааны комиссоос хэрэгжүүлдэг 36 улсын хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах байгууллагуудын хамтарсан <https://econsumer.gov/> цахим хуудас руу хандана уу. Холбооны мөрдөх товчоо (FBI)-ны Интернетийн гэмт хэргийн талаар гомдол хүлээн авах төв буюу [Internet Crime Complaint Center](#)-т хандаж болно. Хүсээгүй имэйлийн талаар гомдол гаргахын тулд <https://econsumer.gov/> цахим хуудасны гомдол гаргах “Телемаркетинг болон Спам” хэрэгсэлийг ашиглах эсвэл [Хууль Зүйн Яамны Хүсээгүй Зар Сурталчилгааны Имэйл \(Спам\)](#) цахим хуудас руу хандаж нэмэлт мэдээлэл болон холбоо барих хаяг авна уу.

DV СТАТИСТИК

38. DV-2022 ХӨТӨЛБӨРТ ХЭДЭН ВИЗ ОЛГОГДОХ ВЭ?

Хуульд заасны дагуу АНУ-ын олон үндэстний цагаачлалын хөтөлбөрөөр шаардлага хангасан хүмүүст жил бүр дээд тал нь 55,000 байнгын оршин суугчийн виз олгох ёстой.

БУСАД

39. ХЭРВЭЭ БИ DV ХӨТӨЛБӨРӨӨР ДАМЖУУЛАН ВИЗ АВБАЛ АНУ-ЫН ЗАСГИЙН ГАЗАР НАДАД ТЭНД БАЙР СУУРИА ОЛТОЛ ТЭНД ХҮРЭХ ОНГОЦНЫ БИЛЕТ, БАЙР СУУЦ, АЖЛЫН БАЙР ОЛЖ ӨГӨХ, ЭРҮҮЛ МЭНД БОЛОН МӨНГӨН ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ ҮҮ?

Үгүй. Та DV хөтөлбөрийн дагуу виз авахад АНУ-ын засгийн газраас танд дээрх үйлчилгээний алиныг нь ч үзүүлэхгүй. Хэрвээ та DV хөтөлбөрт сонгогдож виз мэдүүлэх бол виз авахаасаа өмнө АНУ-д очоод АНУ-ын Засгийн Газраас ямар нэгэн тэтгэмж авахгүй гэдгээ батлан харуулах шаардлагатай. Үүний тулд та тэтгэмж гэж юу болох ямар нотолгоо үзүүлж байж тэтгэмж авахгүй гэдгээ нотолж болох талаарх Төрийн Департаментын олон нийтэд тавигдсан мэдээллийг судлах хэрэгтэй.

УУГУУЛ ИРГЭД НЬ DV-2022 ХӨТӨЛБӨРТ ОРОЛЦОХ ЭРХ БҮХИЙ УЛС ОРНЫ ЖАГСААЛТ (БҮС НУТГААР)

Доорх жагсаалтад уугуул иргэд нь DV-2022 хөтөлбөрт оролцох эрхтэй улс орнуудыг тус хөтөлбөрт мөрддөг газарзүйн бүсээр хувааж жагсаалаа. Хараат нутаг дэвсгэрүүд өөрийн захирагддаг улс орнуудын бүс нутагт багтана. Уугуул иргэд нь DV-2022 хөтөлбөрт оролцох эрхгүй улс орнуудыг АНУ-ын Иргэншил ба Цагаачлалын Алба (USCIS) Цагаачлал, харьяаллын тухай хуулийн 203(с) хэсэгт заасан томъёоллын дагуу тогтоодог. Энэхүү олон үндэстний хөтөлбөрт уугуул иргэд нь оролцох эрхгүй улс орнуудыг (гэр бүлийн болон хөдөлмөр эрхлэлтийн цагаачлалын гол эх сурвалж болсон улс орнууд, өөрөөр хэлбэл "АНУ руу цагаач их гарсан" улс орнууд) тухайн бүс нутгийн улс орны жагсаалтын дараа жич тэмдэглэсэн.

АФРИК

Алжир	Кени
Ангол	Лесото
Бенин	Либериа
Ботсвана	Ливи
Буркино-Фасо	Мадагаскар
Бурунди	Малави
Камерун	Мали
Кабо-Верде	Мавритани
Төв Африкийн Бүгд Найрамдах Улс	Маврик
Чад	Марокко
Коморын арлууд	Мозамбик
Конго	Намиби
Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс	Нигер
Кот д'Ивуар (Зааны ясан эрэг)	Нигери
Джибути	Руанда
Египет*	Сан Томе ба Принсипи
Экваторын Гвиней	Сенегал
Эритрей	Сейшелийн арлууд
Этиоп	Сьерра-Леоне
Габон	Сомали
Гамби	Өмнөд Африк
Гана	Өмнөд Судан
Гвиней	Судан
Гвиней-Биссау	Свазиленд

Танзани	Уганда
Того	Замби
Тунис	Зимбабве

*1967 оны 6 дугаар сараас өмнө Израил, Иордан, Сир болон Египтийн захиргаанд байсан нутаг дэвсгэрт төрсөн хүмүүс Израил, Иордан, Сири болон Египт улсынхаа нэрээр хөтөлбөрт оролцоно. Газын зурваст төрсөн иргэд Египетийн нэрээр, West Bank буюу Баруун эрэгт төрсөн хүмүүс Иорданы нэрээр, Golan Heights (Голан Хаятс) –д төрсөн хүмүүс Сирийн нэрээр хөтөлбөрт оролцох боломжтой.

Африкт Нигерийн уугуул иргэд энэ жилийн олон үндэстний визийн хөтөлбөрт **оролцох эрхгүй**.

АЗИ

Афганистан	Малайз
Бахрейн	Мальдив
Бутан	Монгол
Бруней	Балба
Бирм	Хойд Солонгос
Камбож	Оман
Индонез	Катар
Иран	Саудын Араб
Ирак	Сингапур
Израил*	Шри-Ланк
Япон***	Сири*
Иордан*	Тайвань**
Кувейт	Тайланд
Лаос	Тимор-Лэстэ
Ливан	Арабын Нэгдсэн Эмират
	Йемен

*1967 оны 6 дугаар сараас өмнө Израил, Иордан, Сир болон Египтийн захиргаанд байсан нутаг дэвсгэрт төрсөн хүмүүс Израил, Иордан, Сири болон Египт улсынхаа нэрээр хөтөлбөрт оролцоно. Газын зурваст төрсөн иргэд Египетийн нэрээр, West Bank буюу Баруун эрэгт төрсөн хүмүүс Иорданы нэрээр, Golan Heights (Голан Хаятс) –д төрсөн хүмүүс Сирийн нэрээр хөтөлбөрт оролцох боломжтой.

**Макаогийн Тусгай захиргаатай бүс (Европын бүс нутаг, Португалын нэрээр) болон Тайванийн (Азийн бүс нутаг) уугуул иргэд өргөдөл гаргах эрхтэй бөгөөд дээрх жагсаалтанд багтсан. Зөвхөн олон үндэстний визийн хөтөлбөрт хамруулах зорилгоор Макаогийн Тусгай захиргаатай бүсэд төрсөн хэрнээ Португалаас гаралтай хүмүүс Португалын нэрээр оролцох боломжтой.

*** Хабомаи арлууд, Шикотаи, Кунашир болон Итуруп нутаг дэвсгэрт төрсөн хүмүүс Япон улсын нэрээр хөтөлбөрт оролцоно. Өмнөд Сахалин нутагт төрсөн хүмүүс ОХУ-ын нэрээр оролцоно.

Доор дурдсан Азийн бүсийн улс орнуудын уугуул иргэд энэ жилийн олон үндэстний визийн хөтөлбөрт оролцох **эрхгүй**: Бангладеш, Хятад (Хонконг оролцуулан), Энэтхэг, Пакистан, Өмнөд Солонгос, Филиппин болон Вьетнам.

ЕВРОП

Албани	Лихтенштейн
Андорра	Литва
Армен	Люксембург
Австри	Макаогийн Тусгай захиргаатай бүс**
Азербайжан	Македони
Беларус	Мальта
Бельги	Молдов
Босни Герцеговин	Монако
Болгар	Монтенегро
Хорват	Нидерланд (гадаад дахь эзэмшил болон хараат нутаг дэвсгэрүүдийг оруулна)
Кипр	Умард Ирланд**
Бүгд Найрамдах Чех Улс	Норвеги (гадаад дахь эзэмшил болон хараат нутаг дэвсгэрүүдийг оруулна)
Дани (гадаад дахь эзэмшил болон хараат нутаг дэвсгэрүүдийг оруулна)	Польш
Эстони	Португал (гадаад дахь эзэмшил болон хараат нутаг дэвсгэрүүдийг оруулна)
Финланд	Румын
Франц (гадаад дахь эзэмшил болон хараат нутаг дэвсгэрүүдийг оруулна)	ОХУ****
Гүрж	Сан Марино
Герман	Серби
Грек	Словак
Унгар	Словен
Исланд	Испани
Ирланд	Швед
Итали	Швейцар
Казахстан	Тажикстан
Косова	Турк
Киргизстан	Туркменистан
Латви	

Украин
Узбекистан
Ватикан хот улс

****Макаогийн Тусгай захиргаатай бүс оролцох эрхтэй бөгөөд дээрх жагсаалтанд багтсан бөгөөд зөвхөн олон үндэстний визийн хөтөлбөрт хамруулах зорилгоор Макаогийн Тусгай захиргаатай бүсэд төрсөн хэрнээ Португалаас гаралтай хүмүүс Португалын нэрээр оролцох боломжтой.**

*****Зөвхөн олон үндэстний визийн хөтөлбөрт хамруулах зорилгоор Умард Ирландыг тусад нь авч үздэг бөгөөд Умард Ирланд энэ хөтөлбөрт **оролцох эрхтэй** тул дээрх жагсаалтад орсон.**

****** Хабомаи арлууд, Шикотаи, Кунашир болон Итуруп нутаг дэвсгэрт төрсөн хүмүүс Япон улсын нэрээр хөтөлбөрт оролцоно. Өмнөд Сахалин нутагт төрсөн хүмүүс ОХУ-ын нэрээр оролцоно.**

Доор дурдсан Европын улс орнуудын уугуул иргэд энэ жилийн олон үндэстний хөтөлбөрт **оролцох эрхгүй**: Их Британи (Нэгдсэн Вант Улс). Их Британи (Нэгдсэн Вант Улс)-д дараах хараат нутаг дэвсгэр орно: Ангилья, Бермуд, Британийн Виржинийн арлууд, Британийн Энэтхэгийн далай дахь газар нутаг, Кейманы арлууд, Фолклендийн арлууд, Гибралтар, Монтсеррат, Питкэрн, Хойд Гүрж ба Хойд Сэндвичийн арлууд, Сэнт Элен, Төрс болон Кэйкос арлууд.

ХОЙД АМЕРИК

Багамын арлууд

Хойд Америкийн тухайд Канад болон Мексикийн уугуул иргэд энэ жилийн олон үндэстний визийн хөтөлбөрт оролцох эрхгүй.

НОМХОН ДАЛАЙН ОРНУУД

Австрали (гадаад дахь эзэмшил болон хараат нутаг дэвсгэрүүдийг оруулна)	хараат нутаг дэвсгэрүүдийг оруулна)
Фижи	Палау
Кирибати	Папуа Шинэ Гвиней
Маршаллын арлууд	Соломон арлууд
Микронезийн Холбооны Улсууд	Тонга
Науру	Тувалу
Шинэ Зеланд (гадаад дахь эзэмшил болон	Вануату
	Самоа

ӨМНӨД АМЕРИК, ТӨВ АМЕРИК БОЛОН КАРИБЫН ТЭНГИСИЙН УЛС ОРНУУД

Антигуа Барбуда

Аргентин

Барбадос

Белиз

Боливи

Чили

Коста Рика

Куба

Доминик

Эквадор

Гренад

Гайана

Никарагуа

Панам

Парагвай

Перу

Сэнт Киттс ба Невис

Сэнт Люси

Сэнт Винсент ба Гренадиний арлууд

Суринам

Тринидад ба Тобаго

Уругвай

Венесуэл

Энэ бүсээс уугуул иргэд нь энэ жилийн олон үндэстний визийн хөтөлбөрт **оролцох эрхгүй** улс орнууд: Бразил, Колумби, Бүгд Найрамдах Доминикан Улс, Эль Сальвадор, Гаити, Гондурас, Ямайка, Мексик болон Перу.